МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
Цахим хуудас: www.mmhi.gov.mn

2024.01.25 № 041 198

танай 2020.12.13 -ны № 1/665 -т

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН
АЛБАНД

Үндэсний геологийн албанаас ирүүлсэн 2023 оны гүйцэтгэлийн тайланд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга болон хянан баталгаажуулсан тайланг хүргүүлж байна.

Хавсралт 40 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.БАТБАЯР

1508 11 0202

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Үндэсний геологийн албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилтыг хүрсэн түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Төсвийн ерөнхийлөн захирагч /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд/-аас төсвийн шууд захирагч /Үндэсний геологийн албаны дарга/-тай зөвшилцөн баталсан Үндэсний геологийн албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 27 зорилтын хүрээнд 71 арга хэмжээ тусгагдсан бөгөөд Үндэсний геологийн албанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн ирүүлсэн.

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.2 дах заалтыг тус тус үндэслэн Үндэсний геологийн албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Үндэсний геологийн албаны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилго, 27 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 71 арга хэмжээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг 90 хувийн биелэлттэй гэж дүгнэв.

| № | Зорилтын дугаар | Арга хэмжээний тоо | | Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо | | | | | | Үнэлгээ /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ХАХ | ТАХ | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 1. | Зорилт 1.1. | 2 | 2 | 2 | | | | | | 100 |
| 2. | **Зорилт 1.2.** | **4** | **4** | **1** | **2** | **1** | | | | **87.5** |
| 3. | Зорилт 1.3. | 1 | 1 | | | | | 1 | | 30 |
| 4. | **Зорилт 1.4.** | **3** | **3** | | **3** | | | | | **90** |
| 5. | Зорилт 1.5. | 2 | 2 | 1 | 1 | | | | | 95 |
| 6. | **Зорилт 1.6.** | **1** | **1** | | **1** | | | | | **90** |
| 7. | Зорилт 1.7. | 4 | 4 | 2 | 1 | 1 | | | | 90 |
| 8. | **Зорилт 1.8.** | **2** | **2** | **2** | | | | | | **100** |
| 9. | Зорилт 1.9. | 1 | 1 | 1 | | | | | | 100 |
| 10. | **Зорилт 1.10.** | **1** | **1** | **1** | | | | | | **100** |
| 11. | Зорилт 2.1. | 4 | 4 | 2 | 1 | 1 | | | | 90 |
| 12. | **Зорилт 2.2.** | **2** | **2** | **1** | **1** | | | | | **95** |
| 13. | Зорилт 2.3. | 1 | 1 | | 1 | | | | | 90 |
| 14. | **Зорилт 3.1.** | **3** | **3** | **3** | | | | | | **100** |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15. | Зорилт 3.2. | 4 | 4 | 3 | | 1 | | | | 92.5 |
| 16. | **Зорилт 3.3.** | 2 | 2 | 2 | | | | | | 100 |
| 17. | Зорилт 3.4. | 2 | 2 | 2 | | | | | | 100 |
| 18. | **Зорилт 3.5.** | 3 | 3 | | 2 | 1 | | | | 83.3 |
| 19. | Зорилт 4.1. | 1 | 1 | | | | | 1 | | 30 |
| 20. | **Зорилт 4.2.** | 4 | 4 | 4 | | | | | | 100 |
| 21. | Зорилт 4.3. | 2 | 2 | 2 | | | | | | 100 |
| 22. | **Зорилт 5.1.** | 6 | 6 | 3 | 2 | 1 | | | | 91.7 |
| 23. | Зорилт 5.2. | 1 | 1 | | | 1 | | | | 70 |
| 24. | **Зорилт 5.3.** | 1 | 1 | 1 | | | | | | 100 |
| 25. | Зорилт 5.4. | 7 | 7 | 1 | 5 | | | | 1 | 78.6 |
| 26. | **Зорилт 5.5.** | 3 | 3 | 2 | | | 1 | | | 83.3 |
| 27. | Зорилт 5.6. | 4 | 4 | 3 | 1 | | | | | 97.5 |
| **Нийт дүн** | | **71** | **71** | **39** | **21** | **7** | **1** | **2** | **1** | **90** |

Тайлбар: ХАХ-хэрэгжүүлэх арга хэмжээний тоо, ТАХ-тайлагнасан арга хэмжээний тоо

## Дөрөв. Дүгнэлт

Үндэсний геологийн алба нь 2023 онд 5 зорилго, 27 зорилтын хүрээнд 71 арга хэмжээг хэрэгжүүлсэн ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 90 хувиар үнэлэгдэв. Үүнээс “үр дүнтэй” 10, “тодорхой үр дүнд хүрсэн” 15 зорилт байна. Харин 1.3 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0,15 хувийг хамруулах ажлын бэлтгэл ажлыг хангах; 4.1 Архивын баримтын аюулгүй байдлын баталгааг хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах шат дараалсан арга хэмжээ авах; гэсэн 2 зорилтын хэрэгжилтийг “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Биелэлт нь төлөвлөсөн түвшинд хүрээгүй дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, дараа жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах нь зүйтэй юм.

## Тав. Санал, зөвлөмж

- Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа үйл явцыг дэлгэрэнгүй тоочилгүй, үр дүнг товч, тодорхой бичиж, тайлангийн чанар, утга найруулгыг хянаж, нотлох баримт буюу холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаар, цахим хаяг зэргийг дурдах;

- Гүйцэтгэлийн тайланг жилийн эцсийн байдлаар ирүүлэхдээ хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгын хамт ирүүлж байх;

- Төсвийн ерөнхийлөн захирагч /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд/-аас төсвийн шууд захирагч /Үндэсний геологийн албаны дарга/-тай зөвшилцөн баталсан төлөвлөгөөний дагуу үнэн зөв тайлагнах,
  Тодруулбал, 1.4.2; 1.7.3; 1.8.1; 1.8.2; 1.10.1; 4.3.1; 5.1.3 дах арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин батлагдсан төлөвлөгөө, ирүүлсэн тайланд зөрүүтэй байна. Иймд зорилт, арга хэмжээг хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг илэрхийлсэн, бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан байдлаар төлөвлөж, хийж гүйцэтгэсэн ажлыг бүрэн гүйцэд тайлагнаж, зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг, зорилтот түвшинтэй харьцуулах замаар хэрэгжилтийг үнэн, зөв, бодитой үнэлэх;

- Арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлсэн хэдий ч ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх нь тодорхойгүй, тайлагнасан байдал хангалтгүй байтал “үр дүнтэй” буюу 100 хувиар үнэлсэн нь учир дутагдалтай байна.

- Суурь болон зорилтот түвшинг тоон утгаар илэрхийлсэн арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн

хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1-д заасан аргачлалын $\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$ дагуу үнэлэх;

- Зорилт нь үр дүнд суурилсан, бодитой, биелэгдэхүйц, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь зорилтод, цаашлаад зорилгод чиглэсэн байх гэсэн нийтлэг шаардлагын дагуу арга хэмжээг тодорхойлох;

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны "Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/63 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох тайлан, мэдээг зохих хугацаанд ирүүлж байх.

Танилцсан:
Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Т.Баасанпүрэв

Үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан:
ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Ж.Энхсайхан Ж.Энхсайхан

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

# 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*Тайлан хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

**Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд** ........................ **/Жамбалын Ганбаатар/**

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг*

*Гүйцэтгэл тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

**Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч** ........................ **/Батболдын Мөнхтөр/**

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

| Д/д | № | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /ЗГҮАХ-АХТ/, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө /2020-2024/, Үндэсний геологийн албаны стратеги төлөвлөгөө (2020-2024). | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Үнэлгээ /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО 1. Улсын төсвийн хөрөнгөөр нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, геотехникийн зэрэг зураглал, судалгаа, шинжилгээний ажлыг үе шаттай төлөвлөх, гүйцэтгэх, удирдах** | | | | | | | | |
| Зорилт 1.1.Нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, геоэкологи, гидрогеологийн региональ судалгааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлогын удирдамжийн дагуу гүйцэтгэх | | | | | | | | |
| 1 | 1.1.1 | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй геологийн судалгааны ажлуудын нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 5-ны дотор УУХҮЯ-нд хүргүүлнэ. | - | Тайлангийн тоо | 0 | 4 | 1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Борзонгийн говь-50, Хар хайрхан-50, Овоот толгой-50, , Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Их бэрхийн уул-50, Зангат-50, Цагаан-Овоо-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Овоот шар-50, Үүрэг нуур-50, Ямбат уул-50, Баян зүрх уул-50, Ханхар уул-50, сэдэвчилсэн судалгааны Төв ази 3D 5-р үе шат, Эрэл үнэлгээ-2, Эрэл үнэлгээ-3, Эрэл үнэлгээ-4, ӨТТЭ-1, ӨТТЭ-2, БМШАМ-2022, БМШАМ-2022, Гео-Орчин-2022, Ховд геоэкологи-2019, Ховд-2020, Гүний хагарал-2020, УГЗ-200 нэгтгэл -М, Мезо-Кайнозой, Төв ази 3D 5-р үе шат, Эрэл үнэлгээ-2, Эрэл үнэлгээ-3, Эрэл үнэлгээ-4, ӨТТЭ-1, ӨТТЭ-2 ,БМШАМ-2022, "Мета-алт-500" зэрэг 42 төслийн 2023 оны 1 дүгээр улирлын тайланг хүлээн авч нэгтгэн, УУХҮЯ-нд цахим шуудангаар 2023.06.05-ны өдөр илгээсэн.<br>2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын Баянзүрх уул-50, Борзонгийн говь-50, Бөөн хөх уул-50, Бүйлст хүрэн уул-50, Гилбэнт Уул-50, Загал Уул-50, Зангат-50, Индэртийн нуруу-50, Их Хараат Уул-50, Их бэрх уул-50, Мөст уул-50, Овоот толгой-50, Овоот шар-50, Өндөр ширээт-50, Уушгийн улаан-50, Үнэгт уул-50, Үүрэг нуур-50, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ханхар уул-50, Хар хайрхан-50, Цагаан Овоо-50, Цэцэрлэг-50, Ямаат уул-50, 1:200000-ны масштабын улсын геологийн зураг нэгтгэл УГЗ-200-М нэгтгэл, Сэдэвчилсэн судалгаа Дархан геоэкологи, Ховд геоэкологи, Гео-Орчин-2022, Гүний хагарал-1, Мезо-Кайнозой, Төв ази 3D 5-р үе шат, Эрэл үнэлгээ-2, Эрэл үнэлгээ-3, Эрэл үнэлгээ-4, Өндөр технологийн түүхий эд -1, Өндөр технологийн түүхий эд -2, БМШАМ-2022, Мета алт-2022, Геологийн баримт-1, Чулуун дээжийн сан-1, Цахим архив зэрэг 39 төслийн 2023 оны 02 дугаар улирлын тайланг хүлээн авч нэгтгэн, УУХҮЯ-нд цахим шуудангаар илгээсэн.<br>3. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын Хархайрхан-50, Их элээт уул-50, Цэцэрлэг-50, Их бэрх уул-50, Их хараат уул-50, Цагаан Овоо-50, Индэртийн нуруу -50, Загал-Уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Овоот шар-50, Үүрэг нуур-50, Мөст уу-50, Ямбат уул-50, Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Мезозой-кайнозойн-2021, "Гүний хагарал-1, Гео-орчин-2022, Төв ази 3D 5-р үе шат, Эрэл үнэлгээ-2, Эрэл үнэлгээ-3, Эрэл үнэлгээ-4, ӨТТЭ-1, ӨТТЭ-2, БМШАМ-2022, Мета-алт-500, Геологийн баримт-1, Чулуун дээжийн сан-1, Цахим Архив-2022 зэрэг 32 төслийн 2023 оны 3 дугаар улирлын тайланг хүлээн авч нэгтгэн, УУХҮЯ-нд 2023.10.26-ны өдрийн 2/583 тоот албан бичгээр илгээсэн.<br>Хүрсэн түвшин: Илгээсэн тайлангийн тоо 4.<br>Журмын дагуу дараа сарын 05-нд 4 дүгээр улирлын тайланг илгээх журамтай. | |
| 2 | 1.1.2 | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн сар бүрийн ирүүлсэн гүйцэтгэлийг хянан, нэгтгэж, СЯ, УУХҮЯ-нд хүргүүлнэ. | - | Хүргүүлсэн гүйцэтгэ-лийн тоо | 0 | 12 | -Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 23 сэдэвчилсэн судалгааны 6 нийт 29 төслийн 1 дүгээр сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 418527541 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 22 сэдэвчилсэн судалгааны 5 нийт 27 төслийн 2 дугаар сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 318899459 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 24 сэдэвчилсэн судалгааны 7 нийт 31 төслийн 3 дугаар сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 633644777 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 23 сэдэвчилсэн судалгааны 6 нийт 29 төслийн 4 дүгээр сарын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 608361137 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 23 сэдэвчилсэн судалгааны 7 нийт 30 төслийн 5 дугаар сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 997,699,783 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 23 сэдэвчилсэн судалгааны 6 нийт 29 төслийн 6 дугаар сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 1,329,910,726 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 17 сэдэвчилсэн судалгааны 6 нийт 23 төслийн 7 дугаар сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 1,088,389,656 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 16 сэдэвчилсэн судалгааны 6 нийт 22 төслийн 8 дугаар сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 1,275,521,452 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 15 сэдэвчилсэн судалгааны 5 нийт 20 төслийн 9 дүгээр сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 963,260,748 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 12 сэдэвчилсэн судалгааны 5 нийт 17 төслий 10 дугаар сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 858,007,756 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэсэн.<br>-Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 13 сэдэвчилсэн судалгааны 6 нийт 19 төслийн 11 дүгээр сарын гүйцэтгэлийг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, 2,950,488,165 төгрөгийн гүйцэтгэлийг нэгтгэж, тус тус хүргүүлсэн.<br>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны төслүүдийн 12 дугаар сарын гүйцэтгэлийг хуулийн хугацаанд хүлээн авч, гүйцэтгэлийг хянаж, нэгтгэн хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Хүргүүлсэн гүйцэтгэлийн тоо 12. | |
| Зорилт 1.2. ЗГҮАХ-АХТ 3.2.3.1.1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулах | | | | | | | | |
| 3 | 1.2.1 | Үргэлжлэн хэрэгжиж буй 25 төслийн 2023 оны ажлын | - | Хэлэл- | 0 | 25 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Борзонгийн говь- | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээ, аргачлалын тодотголыг хянаж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлтгэх, хэлэлцүүлнэ. | | цуулсэн тайлангийн тоо | | | 50, Хар хайрхан-50, Овоот толгой-50, Үнэгт уул-50, Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Улаангом-50, Их бэрхийн уул-50, Гилбэнт уул -50, Зангат-50, Цагаан-Овоо-50, Идэртийн нуруу-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Овоот шар-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Баянзүрх уул-50, Ханхар уул-50 төслүүдийн 2023 онд гүйцэтгэх ажлын төсөв, төлөвлөгөөг хянаж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023.02.13-наас 17-ны өдрүүдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 25 төслийн төсвийн тодотголыг батлуулсан. | |
| 4 | 1.2.2 | Улсын төсвийн хөрөнгөөр үргэлжлэн хэрэгжиж буй 25 төслийн суурин болон шуурхай хяналт хийнэ. | - | Хяналт хийсэн төслийн тоо | 0 | 25 | -Дорнод аймгийн Гурванзагал, Дашбалбар, Чулуунхороот сумдын нутагт хэрэгжүүлэх “Монголит” ХХК-ийн гүйцэтгэж буй 1:50000-ны геологийн зураглал ерөнхий эрлийн ажлын Загал уул-50 төсөлд 2023.07.21-26-ны өдрүүдэд УУХҮЯ-ны ГБГ-ын ахлах мэргэжилтэн Б.Баярсайхан, ҮГА-ын геологийн судалгааны хэлтсийн мэргэжилтэн нар,<br>-Өмнөговь аймаг хэрэгжиж байгаа Бөөн хөх уул-50 төсөлд ҮГА-ны ГСХ-ийн мэргэжилтэн, ҮГА-ны ГМТ-ийн дарга, ажилтнуудын бүрэлдхүүнтэй ажлын хэсэг 2023.07.25-28-ны өдрүүдэд,<br>-Баянхонгор, Баян-Өлгий, Увс аймаг хэрэгжиж байгаа Ямбат уул-50, Овоот шар-50, Үүрэг нуур-50 төслүүдэд ҮГА-ны ГСХ-ийн мэргэжилтэн Р.Болд-Эрдэнэ, УУХҮЯ-ны ахлах шинжээч Х.Баярхангай нар 2023.06.28-07.09-нд,<br>-Архангай аймгийн Цахир, Тариат, Хангай сум, Хөвсгөл аймгийн Жаргалант сум, Завхан аймгийн Их уул сумдын нутагт “Монгол алт” ХК-ийн хэрэгжүүлж буй Мөст уул-50 төсөл, Булган аймгийн Бүрэгхангай, Орхон сум, Орхон уул аймгийн Баян-Өндөр сумдын нутагт “Эрээн чулуу” ХХК-ийн хэрэгжүүлж буй Баянзүрх уул-50 төсөл, Булган аймгийн Бүрэгхангай, Орхон сум, Орхон уул аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутагт “Гео эрэл зураглал” ХХК-ийн хэрэгжүүлж буй Ханхар уул-50 төслүүдэд 2023.08.04-12-ны өдрүүдэд ҮГА-ны ГСХ-ийн мэргэжилтэн, ГХНЗ-ийн гишүүн Монгол Улсын зөвлөх геологич Б.Дэлгэрцогт, Монголын эмэгтэй геологичдын холбооны тэргүүн Ч.Энхтуяа нар,<br>-Баянхонгор, Өмнөговь аймагт хэрэгжиж байгаа Ямбат уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Ямаат уул-50, Буйлс хүрэн уул-50 төслүүдэд ҮГА-ны ГСХ-ийн мэргэжилтэн, УУХҮЯ-ны ахлах мэргэжилтэн, ГНХолбооны төлөөлөл Б.Батаа нарын ажлын хэсэг 2023.09.12-20 өдрүүдэд,<br>2023 оны хээрийн үйлдвэрлэлийн ажил, завсрын суурин боловсруулалт, сар бүрийн ирүүлсэн гүйцэтгэлийг газар дээр нь баталгаажуулах, хэмжилт, хяналт хийх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 1.2.3 | Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжиж дуусах төслүүдийн үр дүнгийн тайланг хянан, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж, нутаг дэвсгэрийн хамрагдах хэмжээг нэмэгдүүлнэ. | - | Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь | 44 | 46 | Борзонгийн говь-50, Хар хайрхан-50, Овоот толгой-50, Үнэгт уул-50, Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Улаангом-50, Их бэрхийн уул-50, Гилбэнт уул -50, Зангат-50 гэсэн нийт 13 төслийн үр дүнгийн тайлан зохиох ажлын явцад шуурхай хяналтыг 2023.03.20-04.04-ний хугацаанд хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг шийдвэрлэх, хугацаатай үүр даалгавар өгч, тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. | 70 |
| 6 | 1.2.4 | Үргэлжлэн хэрэгжиж буй 25 төслийн суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авна. | - | Хүлээн авсан төслийн тоо | 0 | 25 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Борзонгийн говь-50, Хар хайрхан-50, Цэцэрлэг-50, Овоот толгой-50, Торлог уул-50, Их хараат уул-50, Идэртийн нуруу-50, Үнэгт уул-50, Мөст уул-50, Их элээт уул-50, Ямбат уул-50, Уушгийн улаан-50, Улаангом-50, Их бэрхийн уул-50, Гилбэнт уул-50, Зангат-50 , Ханхар уул-50, Баян зүрх уул-50, Буйлст хүрэн уул-50, Цагаан-Овоо-50, Загал уул-50, Ямаат уул-50, Бөөн хөх уул-50, Овоот шар-50, Үүрэг нуур-50 2023 онд гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, үр дүнд, чанар, хэрэгжилтэд хяналт хийсэн.<br>Хүрсэн түвшин: 25 төслийн хээрийн материалыг төлөвлөгөөт хугацаанд хүлээн авсан. | 100 |
| **Зорилт 1.3. 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0,15 хувийг хамруулах ажлын бэлтгэл ажлыг хангах /ЗГҮАХ-АХТ 3.2.3.2/** | | | | | | | |
| 7 | 1.3.1 | 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажил гүйцэтгэх заавар, түүнд тавих шаардлага төслийг боловсруулна. | - | Ажлын явц хувь | 0 | 100 | 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг<br>-2023 Ханан хад-25<br>-2024 онд Хархорин-25,<br>-2025 онд Майдар-25,<br>-2026 онд Чойбалсан-25<br>-төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, холбогдох тооцоо, судалгааны хамт УУХҮЯ-нд 2023.03.21-ний өдрийн 1/163 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>УУХҮЯ-нд төслүүдийн асуудлаар санал авахаар жил бүр хүргүүлж байсан боловч хэрэгжүүлэх төсөв болон саналыг ирүүлээгүй тул ҮГА-наас үл хамаарч байна. | 30 |
| **Зорилт 1.4. ЗГҮАХХ-АХТ 3.2.3.3. Улсын геологийн 1:200000-ны масштабын их бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулах** | | | | | | | |
| 8 | 1.4.1 | УГЗ-200 L нэгтгэл төслийн эдийн засгийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хурлаар хэлэлцүүлэх, нутаг дэвсгэрийн хамрагдах хэмжээг нэмэгдүүлнэ. | - | Нутаг дэвсгэрийн хамрагдах хувь | 14 | 67,8 | Улсын геологийн 1:200000-ны масштабтай иж бүрдэл зургуудыг 2019-2022 онд нэгтгэх төслийн зураг, тайлбар бичиг бүрэн зохиогдсон.<br>Хүрсэн түвшин: ЭБМЗ-ийн хурал товыг хүлээж байна. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 1.4.2 | УГЗ-200-М нэгтгэл төслийн хэрэгжилтийг хангах, ажлын гүйцэтгэл үр дүнд тайлангийн шуурхай хяналт хийх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллана. | - | Хяналт хийсэн төслийн тоо | 0 | 1 | УГЗ-200 М нэгтгэл төслийн эцсийн үр дүнгийн тайлан боловсруулалтын явцад шуурхай хяналтыг 2023.03.31-ний өдөр хийж, төслийн явц, чанар, үр дүнд хяналт хийсэн.<br>Хүрсэн түвшин: Төсөлд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. | 90 |
| 10 | 1.4.3 | УГЗ-200-М нэгтгэл төслийн үр дүнгийн тайланд шуурхай хяналт хийх, судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авна. | | Хяналт хийж, хүлээн авсан төслийн тоо | 0 | 1 | УГЗ-200 М нэгтгэл төслийн эцсийн үр дүнгийн тайлан боловсруулалтын явцад шуурхай хяналтыг 2023.03.31-ний өдөр хийж, төслийн явц, чанар, үр дүнд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан.<br>М нэгтгэл төслийн багаас гарсан төслийн геологийн даалгаврын хугацааг 6 сараар сунгуулах хүсэлтийг ҮГА-ны даргын тушаалаар томилогдсон 2023 оны хээрийн материал хүлээн авах ажлын хэсэг хуралдаанаар үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн.<br>Хүрсэн түвшин: Төслийн явц, чанар үр дүнд шинжилгээ хийж, хугацааг 6 сараар сунгасан. | 90 |
| **Зорилт 1.5. ЗГҮАХХ-АХТ 3.2.3.4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулах** | | | | | | | | |
| 11 | 1.5.1 | Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Ховд-1" төслийн 2023 оны ажлын хэмжээ, арга аргачлалын тодотголын хэмжээг хянаж, үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлнэ. | - | Төслийн тоо | 0 | 1 | 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр төслийн тайлан боловсруулалтын явцад шуурхай хяналт хийж, төслийн явц, чанар, үр дүнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. | 90 |
| 12 | 1.5.2 | Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Ховд-2020" төслийн үр дүнгийн тайланд шуурхай хяналт хийх, судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авна. | - | Хяналт хийж, хүлээн авсан төслийн тоо | 0 | 1 | Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Ховд-1" төслийн 2023 онд гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, үр дүнд, чанар, хэрэгжилтэд хяналт хийж, 2023.11.13-ны өдөр хээрийн материал хүлээн авсан.<br>Хүрсэн түвшин: Хүлээн авсан төслийн тоо 1. | 100 |
| **Зорилт 1.6. ЗГҮАХХ-АХТ 3.2.3.5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100% хамруулах** | | | | | | | | |
| 13 | 1.6.1 | Монгол орны нутаг дэвсгэрт хийгдэх 1:1000000-ын масштабын геохимийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны төслийг үр дүнгийн тайланг хянаж, Эрдэс | - | Нутаг дэвсгэрийн хамрагдалт, хувь | 26,5 | 100 | Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1149529 $км^2$ талбайн дараах Геохимийн зураглалын үр дүнгийн зургуудыг боловсруулж, тайлбар бичгийн хамт хэвлэж гаргасан. Үүнд:<br>➢Гол 7 ислүүдийн зургууд(SiO 2 Al 2 O 3 Fe 2 O 3 MgO, CaO, Na 2 O, K 2 OO)<br>➢Газрын ховор 14 элементүүдийн зургууд (La, Ce, Pr, Nd, Sm, Eu, Gd, Tb, Dy, Ho, Er, Tm, Yb, LuLu) | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэх, нутаг дэвсгэрийн хамрагдах хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | ➢Геохимийн сарнимал элементүүдийн зургууд (Ag, As, Au, Ba, Be, Bi,Cd, Co, Cr, Cs, Cu, F, Ga, Ge, Hf, Hg, In, Li, Mn, Mo, Nb, Ni, P, Pb, Rb, S, Sb, Sc, Se, Sn, Sr, Ta, Te, Th, Ti, Tl, U, V, W, Zn, Zr, Y, Corg, TC (Нийт нүүрстөрөгчнүүрстөрөгч)<br>➢Геохимийн эвшлийн зургууд11 (Тайланд хавсралтаар А 4 хэмжээгээр орсон)<br>➢Газрын ховор элементүүдийн нийлбэр/SUMREE/ зураг,<br>➢Хөнгөн газрын ховор элементүүдийн нийлбэр / зураг,<br>➢Хүнд газрын ховор элементүүдийн нийлбэр /HREE/ зураг,<br>➢Халькофиль сидерофиль литофиль элементүүдийн тархалтын зураг<br>➢Эрлийн геохимийн үр дүнгийн зургууд<br>➢Үнэт металлын индексийн (СН*6Х) геохимийн зураг<br>➢ Ховор металл индексийн (PEG-4) зураг<br>➢ Үнэт ховор ГХЭ гадаргын бүслүүржилтийн зураг (RGB)<br>Нийт 65 1010=75 ширхэг зургийг хэвлэж, Геологийн даалгаврийн дагуу 73 элементүүдийн зургуудыг А 0 хэмжээгээр, цомог болгон хэвлэж бусад зургуудыг тоон хэлбэрээр тайланд оруулж тайлбарласан.<br>Улсын геологийн зургийн редакцын зөвлөлийн гишүүд дараах зургуудад редакц хийж байна. Үүнд: Гол 7 ислүүдийн зургууд болон Газрын ховор 14 элементүүдийн зургууд -Д.Оролмаа, Геохимийн сарнимал элементүүдийн зургуудыг Г.Дэжидмаа, Геохимийн эвшлийн 11 зургуудыг О.Мөнхцэцэг, О.Гэрэл, Г.Дэжидмаа, Газрын ховор элементүүдийн зургийг О.Гэрэл, Халькофиль-сидерофиль-литофиль элементүүдийн тархалтын зургийг О.Мөнхцэцэг, Эрлийн геохимийн үр дүнгийн зургууд А. Готовсүрэн нараар гүйцэтгүүлэх ажил хийгдэж байна.<br>Хүрсэн түвшин: Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. Хурлын товыг хүлээж байна. | |
| **Зорилт 1.7. ЗГҮАХ-АХТ 3.2.3.6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх** | | | | | | | | |
| 14 | 1.7.1 | Улаанбаатар болон Эрдэнэт геоэкологи төслийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. | - | Төслийн тоо | 0 | 1 | УБ-геоэкологи-2017, Эрдэнэт геоэкологи-2021 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2023.04.10, 13-ны өдрүүдийн /УТХ-2023-06 дугаар/ хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 2 төслийн тайланг Монгол Улсын геологийн мэдээллийн санд хүлээн авах шийдвэр, дүгнэлт гарсан. | 100 |
| 15 | 1.7.2 | Дархан геоэкологи болон Ховд геоэкологи, Гүний хагарал, Гео-Орчин-2022 төслийн мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангах, Эрдэс баялгийн мэргэжлийн | - | Хэлэлцүүл-сэн төслийн тоо | 0 | 4 | Дархан геоэкологи-2020, Ховд геоэкологи-2021 төслүүдийн эцсийн үр дүнгийн тайлан зохиох ажлын явцад 2023.03.29, 30-ны өдрүүдэд шуурхай хяналтыг хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг шийдвэрлэх, хугацаатай үүрэг даалгавар өгөх, тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлнэ. | | | | | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | |
| 16 | 1.7.3 | Гео-Орчин-2022 төслийн хээрийн үйлдвэрлэлийн явцад шуурхай хяналт хийх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, хээрийн материалыг хүлээн авна. | - | Хяналт хийсэн төслийн тоо | 0 | 1 | Гео-Орчин-2022 төсөлд Дархан уул, Сэлэнгэ аймагт хээрийн үйлдвэрлэлийн ажил гүйцэтгэж байхад 2023.07.30-08.05-ны өдрүүдэд УУХҮЯ-ны ГБГ-ын ахлах шинжээч, ҮГА-ны Геологийн судалгааны хэлтсийн мэргэжилтэн, Монголын Геологийн Холбоодын Нэгдсэн Зөвлөлийн Д.Оюун нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2023 оны хээрийн үйлдвэрлэл, завсрын суурин боловсруулалт, ажлын гүйцэтгэлд төлөвлөгөөт хээрийн шуурхай хяналт хийсэн.<br>Хүрсэн түвшин: Хяналт хийсэн төслийн тоо-1. | 90 |
| 17 | 1.7.4 | Дархан геоэкологи, Ховд геоэкологи, Гүний хагарал төслийн үр дүнд тайлангийн шуурхай хяналт хийх, судалгааны ажлын анхдагч материал хүлээн авна. | | Хяналт хийсэн төслийн тоо | 0 | 3 | Дархан геоэкологи, Ховд геоэкологи, Гүний хагарал төслүүдийн 2023 онд гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, үр дүнд, чанар, хэрэгжилтэд хяналт хийж, 2023.11.09-17-ны өдөр мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж, хээрийн материалыг хүлээн авсан. Дархан геоэкологи, Ховд геоэкологи 2 төслийн үр дүнгийн тайланг УГЗ редакцаар оруулж дүгнэлт гаргуулах зэрэг 3 төслийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн байна. | 100 |
| **Зорилт 1.8 ЗГҮАХ-АХТ 3.2.3.7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ.** | | | | | | | | |
| 18 | 1.8.1 | Мезой-Кайнозой төслийн тайлан боловсруулалтын явцад шуурхай хяналт хийх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, хээрийн материалыг хүлээн авах, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулж, хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангана. | - | Хэлэлцүүл-сэн төслийн тоо | 0 | 1 | 2023.03.31-ний өдөр Мезо-кайнозой-21 төслийн тайлан боловсруулалтын явцад шуурхай хяналтыг хийж, төслийн явц, чанар, үр дүнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан.<br>Хүрсэн түвшин: Хэлэлцүүлсэн төслийн тоо: 1. | 100 |
| 19 | 1.8.2 | Мезой-Кайнозой төслийн тайлан боловсруулалтын явцад шуурхай хяналт хийх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, хээрийн материалыг хүлээн авах, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулж, хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангана. | - | Хэлэлцүүл-сэн төслийн тоо<br><br>Хяналт хийсэн төслийн тоо | 0 | 1 | “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:500000-ны масштабтай мезозой, кайнозойн зураг зохиох” сэдэвт судалгааны ажлын “Мезо-кайнозой-21” төслийн 2023 оны төлөвлөгөө, арга, аргачлал, тоо, хэмжээг хянаж, ЭБМЗ-ийн 2023.02.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 557,492,755 төгрөгийн ажлыг төсвийн тодотголоор батлуулсан. 2023.03.31-ний өдөр Мезо-кайнозой-21 төслийн тайлан боловсруулалтын явцад шуурхай хяналтыг хийж, төслийн явц, чанар, үр дүнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан.<br>Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Ховд-1" төслийн 2023 оны хээрийн материалыг 2023.11.27-ны өдөр хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: 2023 оны хээрийн материалыг 2023.11.27-ны өдөр хүлээн авсан.<br>Хүрсэн түвшин: Хэлэлцүүлсэн төслийн тоо: 1. | |
| **Зорилт 1.9. Геологийн судалгаа болон хайгуулын ажлын дээж, сорьцыг гадаад улсын лабораториды шинжлүүлэхээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай тодорхойлолт гаргах** | | | | | | | |
| 20 | 1.9.1 | “Монгол Улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох” зааврын дагуу геологи-хайгуулын болон бусад холбогдох судалгаа шинжилгээний ажлын хүрээнд гадаад орнуудад шинжилгээ хийлгэх дээжид тодорхойлолт олгох, мэдээллийн сан хөтөлнө. | - | Тодорхой-лолтын тоо | 0 | 22 | -Монгол Улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэх 55 хүсэлтийг хүлээн авч судлан, тодорхойлолт албан тоотоор хүргүүлсэн.<br>-Хилээр нэвтрүүлсэн дээжийн 55 мэдээллийг бүртгэлийн санд оруулсан.<br>Хүрсэн түвшин: Нийт 77 хүсэлтийг мэдээллийн санд бүртгэсэн. | 100 |
| **Зорилт 1.10. Геологийн судалгааны ажил гүйцэтгэгч хуулийн этгээдийг оролцуулан судалгааны ажлын үр дүн, чанарыг дээшлүүлэх чиглэлээр уулзалт, сургалт зохион байгуулах, ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах** | | | | | | | |
| 21 | 1.10.1 | Хэрэгжиж буй төслүүдийн дунд ажил мэргэжлийн болон сургалт зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 0 | 1 | Монгол Улсын Их Сургууль, “Геологийн Судалгаа-Шинжилгээний Төв” ТӨҮГ-тай хамтран салбарын залуу боловсон хүчнийг чадавхжуулах зорилгоор “ГЕОЛОГИЙН СУДАЛГАА” сэдэвт сургалтыг 2023.05.01-02-ны өдөр Монгол Улсын Их Сургуулийн багш, оюутны хөгжлийн төвд зохион байгуулсан.<br>Үр дүн: Сургалтад нийт 110 гаруй инженер геологичид хамрагдаж, суралцагсдад батламж олгосон. | 100 |
| **ЗОРИЛГО 2. Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений суурь судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ашигт малтмалын эрлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бүс, зангилгаа, талбайг ялгах ажлыг зохион байгуулах** | | | | | | | |
| Зорилт 2.1. Шинэ сэргээлтийн бодлого-3.1.2, ЗГҮАХ-3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл,хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулах | | | | | | | |
| 22 | 2.1.1 | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгааны төслүүдийн ажлын хэмжээ, арга аргачлалын тодотголыг хянаж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлнэ. | - | Хэлэлцүүл-сэн төслийн тоо | 0 | 8 | 1.“Меланж сурвэй” ХХК-ийн гүйцэтгэж байгаа Эрэл үнэлгээ-2 төслийг ЭБМЗ-ийн хурлаар 2023.02.14-ний өдөр хэлэлцүүлж, 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг зөвшөөрч, төсөв 342,454,127.0 төгрөгөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/170 дугаар тушаалаар батлагдсан.<br>2.“Геосигналс” ХХК-ийн гүйцэтгэж байгаа Эрэл үнэлгээ-3 төслийг ЭБМЗ-ийн хурлаар 2023.03.03-ны өдөр хэлэлцүүлж, 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг зөвшөөрч, төсөв 242,950,547.0 төгрөгөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/192 дугаар тушаалаар батлагдсан.<br>3.“Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨААТҮГ-ын гүйцэтгэж байгаа Монгол улс, ОХУ, БНХАУ, БНСУ-ын “Хойт-Төв-Зүүн Азийн хамтарсан төслийн 5 дэх үе шатны төслийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ЭБМЗ-ийн хурлаар 2023.02.14-ний өдөр хэлэлцүүлж, 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг зөвшөөрч, төсөв 227,995,330.0 төгрөгөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/171 дүгээр тушаалаар батлагдсан.<br>4.“Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨААТҮГ-ын гүйцэтгэж байгаа ӨТТЭ-I төслийг ЭБМЗ-ийн хурлаар 2023.02.14-ний өдөр хэлэлцүүлж, 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг зөвшөөрч, төсөв 170,142,533.0 төгрөгөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/172 дугаар тушаалаар батлагдсан.<br>5.“Демон инженеринг” ХХК-ийн гүйцэтгэж байгаа ӨТТЭ-II төслийг ЭБМЗ-ийн хурлаар 2023.02.17-ны өдөр хэлэлцүүлж, 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг зөвшөөрч, төсөв 2,249,005,139.0 төгрөгөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар батлагдсан.<br>6.“Судалтмана” ХХК-ийн гүйцэтгэж байгаа БМШАМ төслийг ЭБМЗ-ийн хурлаар 2023.02.17-ны өдөр хэлэлцүүлж, 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг зөвшөөрч төсөв 581,078,941.0 төгрөгөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан.<br>6.“Магнетиксурвэй” ХХК-ийн гүйцэтгэж байгаа Мета-алт төслийг ЭБМЗ-ийн хурлаар 2023.02.17-ны өдөр хэлэлцүүлж, 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг зөвшөөрч төсөв 1,087,050,307.0 төгрөгөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/185 дугаар тушаалаар батлагдсан.<br>7.“Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨААТҮГ-ын гүйцэтгэж байгаа Эрэл үнэлгээ-4 төслийг ЭБМЗ-ийн хурлаар 2023.02.17-ны өдөр хэлэлцүүлж, 2023 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг зөвшөөрч төсөв 3,960,308,514.0 төгрөгөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.19-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар батлагдсан.<br>Хүрсэн түвшин: Хэлэлцүүлсэн төсөл-8. УУХҮ-ийн сайдын тушаалаар төсөв батлагдсан. | |
| 51 | 5.1.2 | Төрийн албаны зөвлөлд мэдээ, мэдээлэл, шилжилт хөдөлгөөний талаарх тайланг хүргүүлнэ. | - | Мэдээ тайлангийн тоо | 0 | 2 | -Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд: Ажлаас чөлөөлөгдсөн 9, ажилд томилогдсон 13, жирэмсний болон амаржсаны амралт олгосон 1, хавсран гүйцэтгүүлсэн 3, шилжүүлсэн 3, ТҮ-ний ахлах зэрэг олгосон 2, нийт давхардсан тоогоор 31 албан хаагчийн өөрчлөлт хөдөлгөөнийг бүртгэсэн байна.<br><br>Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим систем шинэчлэгдсэн тул нийт давхардсан тоогоор 31 албан хаагчийн хувийн мэдээллийг шинэчлэн, ажилласан жилийг Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн бүртгэлтэй нийцүүлсэн.<br>Албаны даргын 2023.01.24-ний өдрийн А/01, 2023.07.24-ний өдрийн А/21 дүгээр тушаалаар Төрийн захиргааны албан хаагчдын, 2023.01.24-ний өдрийн А/03, 2023.07.24-ний өдрийн А/22 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний албан хаагчдын | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цалингийн хэмжээг тус тус нэмэгдүүлсэн учир холбогдох мэдээллийг Хүний нөөцийн системд шинэчлэн бүртгэлжүүлэв.<br>Төрийн захиргааны ахлах тэргүүн түшмэлийн албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл, нийт албан хаагчдын төрд, улсад ажилласан жилийн судалгаа, ээлжийн амралт, цалингийн ангилал, шатлалын тооцоолол, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу томилогдсон албан хаагчдын судалгаа зэрэг мэдээллийг шинэчлэн, холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллав.<br>ТАСЗ-д албаны албан хаагчдад зэрэг дэв шинээр олгох, ахиулах асуудлыг танилцуулсан ба УУХҮ-ийн сайдын 2023.04.14-ний өдрийн А/113 дугаар тушаалаар 1 албан хаагчид шинээр, 5 албан хаагчид ахиулан зэрэг дэв олгуулсан. Мөн УУХҮ-ийн сайдын 2023.08.31-ний өдрийн А/284 дүгээр тушаалаар 1 албан хаагчид зэрэг дэв ахиулан олгуулсан. Албаны даргын 2023.09.14-ний өдрийн Б/38, Б/39 дүгээр тушаалаар ТҮ-ний 2 албан хаагчид ахлах зэрэг олгох ажлыг зохион байгуулж ажиллав.<br>Батлагдсан бүтцийн дагуу 2023.03.20-ны өдрийн 2/159 дугаартай албан бичгээр Төрийн захиргааны 1 удирдах албан тушаал, 5 гүйцэтгэх албан тушаал, нийт 6 албан тушаалд, 2023.07.21-ны өдрийн 1/374 дугаартай албан бичгээр 4 гүйцэтгэх албан тушаалд тусгай шалгалт зарлуулах хүсэлтийг УУХҮЯамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, ГСХ-ийн дарга, Эрчим хүч, өндөр технологийн түүхий эдийн судалгаа, нөөцийн баланс хариуцсан мэргэжилтэн, Эрдэс баялгийн үнэлгээ нормчлол, эдийн засгийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр бүхий хүмүүс жинхэлж томилогдсон. | |
| 52 | 5.1.3 | -Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Үндэсний геологийн албаны 17 нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогыг мэдүүлгийг гаргуулан, тайланг хүргүүлнэ. | - | Мэдүүлэг гаргасан албан тушаалтны тоо | 0<br><br>0 | 17<br><br>1 | - Авилгатай тэмцэх газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 03/17067 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Үндэсний геологийн албаны төрийн захиргааны албан хаагчдын ХАСХОМ хүлээн авсан бүртгэл, ХАСУМ бүртгэл, мэдэгдэл, тайлбар, Үндэсний геологийн албаны зохион байгуулалтын бүтцийн ерөнхий бүдүүвч, Албаны Стратеги зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт үндэслэн ХАСХОМ бүрдүүлэх гаргавал зохих албан хаагчид, 2022 оны ХАСХОМ мэдүүлэх үүрэгтэй мэдүүлэг гаргачдын жагсаалтыг гаргасан.<br>- Нийт мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1/02 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | -"Авлигын эсрэг төлөвлөгөө" боловсруулсан байна. | | Төлөвлөгөө батлагдсан эсэх:<br>0-үгүй<br>1-тийм | | | - ХАСХОМ гаргавал зохих 19 төрийн захиргааны албан хаагч байхаас 2 сул ажлын байр нөхөгдөөгүй тул 17 албан хаагчийн ХАСХОМ-ыг шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийлгүүлэн, хуулийн хугацаанд баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн.<br><br>- Тайлант хугацаанд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт гараагүй. Шинээр томилогдох болон ажил хавсран гүйцэтгэхтэй холбоотой 6 албан хаагчийн ХАСУМ эрх нээх хүсэлтийг хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br><br>- Үндэсний геологийн албаны албан хаагчдын 2022 оны ХАСХОМ тайлан мэдээг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 2/126 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br>- Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2022 оны тайлан;<br>- Албан тушаалтны 2022 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээлэл;<br>- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл;<br>- Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээлэл.<br>- Албан хаагчдын 2022 оны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл.<br>- Хүрсэн түвшин: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж ажиллав. | |
| 53 | 5.1.4 | Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулна. | - | Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулсан орны тоо | 0 | 1 | 2023 онд дараах орнуудтай гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Үүнд:<br>Бүгд Найрамдах Солонгос Улстай:<br>Үндэсний геологийн алба болон БНСУ-ын Геологи, эрдэс баялгийн хүрээлэн (KIGAM) хооронд хамтран ажиллах талаар байгуулсан санамж бичиг, мөн Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын хамтарсан хорооны VI хуралдааны хүрээнд хэлэлцэгдсэн ажлын төлөвлөгөөнд 2023 оноос геологийн суурь судалгааны чиглэлээр Баян-Өлгий аймгийн нутагт байрших ховор элементийн эрдэсжилттэй Хаг нэртэй талбайд хамтарсан судалгааг хэрэгжүүлж байна. КИГАМ-2023 оны хээрийн ажлын үр дүнгийн тайланг урьдчилсан байдлаар ирүүлэхдээ тухайн талбайн соронзон зураглалын үр дүн сонирхол татахуйц гарсан тул дараагийн шатны судалгаа хийх дүгнэлт гарсан тухай мэдэгдээд байна. 2023.12.15-ны дотор ҮГА-нд үр дүнгийн тайлан онлайн хэлбэрээр болон биечлэн тайлагнасан.<br>Монгол Улсын Үндэсний геологийн алба болон БНСУ-ын Геологи, эрдэс баялгийн хүрээлэн (КИГАМ) хооронд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2023.07.18-ны өдөр байгуулсан “Олон улсын геологийн 37-р конгресс 2024”-ын хүрээнд (IGC-2024) Монгол Улс дахь геологийн сонирхолтой тогтоцыг түшиглэсэн хээрийн аяллыг хамтран зохион байгуулахад бэлэн болсон.<br>Бүгд Найрамдах Польш Улстай:<br>Монгол Улсын Үндэсний геологийн алба, Польш улсын Геологийн хүрээлэнтай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд “Бэлийн булаг, Задгай булаг дахь молибден, гянтболдыг судлах тойм судалгаа”-г хамтран хэрэгжүүлж байна. 2023 онд Бэлийн булгийн талбайд 5 геологич, Задгай булгийн талбайд 6 геологич хоёр сарын хугацаанд хээрийн ажлыг гүйцэтгэв. 2023 оны хээрийн ажлын явцад авсан дээжүүдийг ГСШТ ТӨҮГ-ийн лабораторт 1161 ширхэг, Польшийн геологийн хүрээлэнд 162 ширхэгийг тус тус шинжлүүлж байгаа бөгөөд лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн 2023 оны судалгааны ажлын үр дүнг тайлагнаж, 2024 оны гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, танилцсан.<br>Бүгд Найрамдах Франц улстай:<br>Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны чиглэлээр Бүгд найрамдах Франц улсын Геологи уул уурхайн судалгааны товчоотой хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, хамтарсан судалгааны ажил хийх, техник технологийн мэдээллийг солилцох чиглэлээр 2023 оны 10 дугаар сард Харилцан ойлголцлын Санамж бичиг Парис хотноо байгуулсан.<br>Австралийн Холбооны Улстай:<br>AMEP хөтөлбөрийн хүрээнд геологийн судалгааны чиглэлээрх MonGeoCat (сүүлийн 6 жилд 100 орчим улс, 42000 хэрэглэгч хандсан), MonGeoMin, MonGeoCol зэрэг системүүдийг амжилттай хэрэгжүүлж үндэсний геомэдээллийн санг сайжруулсан.<br>Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай:<br>Тус улсын BGR төслийн хүрээнд 1:200000-ны масштабтай зургийн өгөгдлийн сангийн орчин үеийн стандарт бүхий шинэ схемийг хөгжүүлэх, "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, эдийн засгийн үнэлгээ, тайлангийн олон улсын стандарт" сэдэвт сургалт, зөвөлгөөн зохион байгуулах, Систем, сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал, ArcGIS Pro, ESRI, ArcMAp, ArcGIS pro, Micromine, Leapfrog программ ашиглах сургалтууд болон геологчдыг мэргэшүүлэх сургалтын гэрээ байгуулж, давхардсан тоогоор 14 хүн хамрагдсан.<br>Хүрсэн дүн: Албаны харилцаж буй геологийн чиглэлээрх гадаад улс орнууд өргөжсөн.<br>Байгуулсан Санамж бичгийн тоо: 2, байгуулсан гэрээ 1. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | 5.1.5 | Жендерийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах, жендерийн судалгаа гаргах, сургалт зохион байгуулсан байна. | - | Сургалт зохион байгуулсан эсэх 0-Үгүй; 1-Тийм | 0 | 1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн 2022 оны мэдээг ЖҮХ-ны мэргэжилтэнд 2023.01.03-ны өдөр мэйлээр хүргэгдсэн.<br>Албаны албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын жилийн мэдээ УУХҮЯ-нд хүргэгдсэн.<br>2023.06.20-нд болсон "Олборлох салбарын жендэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний эхэн үеийн хэрэгжилтийн тайланд хийсэн үнэлгээний дагуу цаашдын төлөвлөлтөд зөвлөмж дүгнэлт өгөх семинар"-т 1, 2023.09.30-нд болсон "Ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ" цахим сургалтад 5, 2023.11.01-нд болсон "Жендэрийн мэдрэмжтэй харилцаа, холбоо цахим сургалт"-д 1 албан хаагч хамрагдсан.<br>Жендэрийн үндэсний хорооноос 2023.03.23, 24-нд зохион байгуулсан "Жендэрийн үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтад хамрагдсан.<br>2023.04.11-нд "Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" үндэсний форумд оролцсон.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Монгол Улсын Засгийн газрын тайланд тусгах мэдээллийг 2023.08.01-ний өдрийн 1/401 дугаартай албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн.<br>Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Хүйсийн 60:40 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах" талаар заасан ба манай байгууллага эрэгтэй албан хаагч 10, эмэгтэй албан хаагч 20 буюу 67:33 гэсэн хүйсийн харьцаатай ажиллаж байна. | 100 |
| 55 | 5.1.6 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврын хэрэгжилтийг хангаж, албан бичгийн шийдвэрлэлтийг сайжруулна. | - | Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, холбогдох журмын дагуу шийдвэр-лэлтийн хувь | 91% | 92% | 2023 онд байгууллагын хэмжээнд ирсэн бичиг 1117, явуулсан бичиг 628, өргөдөл гомдол 31 байна.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг УУХҮЯ-нд 1/8, 2/164, 1/304, 1/538 тоот албан бичгээр улирал бүр хүргүүлсэн байна.<br>Ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн байдал 97.5 хувьтай байгаа бөгөөд хяналтад 10 бичиг байна.<br>Тайлант хугацаанд үйл ажиллагааны чиглэлээр 38, боловсон хүчний чиглэлээр 59 , нөөц бүртгэх 72 тушаал гарсан бөгөөд, тушаалын төслүүд, 628 албан бичгийн төслүүдийг хянаж, хэвлэмэл хуудсанд буулгаж, баталгаажуулсан.<br>2023.06.15-нд Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийг албан хаагчдад таниулах, албан бичгийн боловсруулалт, хэрэг бүрдүүлэлт, албан бичгийн стандарт, архивын баримт бүрдүүлэх, цахим албан хэргийн талаар сургалтанд албан хаагчид 97 хувийн ирцтэй оролцсон. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад нэгжүүдээс авсан саналыг авч хадгалах хугацааг байгууллагын БНШК-оор оруулж байна. Салбарын үлгэрчилсэн жагсаалтыг батлуулах талаар АЕГ-ын мэргэжилтэн ирж харилцан санал солилцсон бөгөөд салбарын үйл ажиллагаанд хөтлөгдөж байгаа баримт бичгийн хадгалах хугацааны санал хүргүүлж ажиллав. | |
| **Зорилт 5.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах** | | | | | | | | |
| 56 | 5.2.1 | Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулах, ажилтан, албан хаагчдыг богино, дунд хугацаат сургалтад жигд хамруулах ажлыг зохион байгуулна. | - | Хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 5 | 2023 оны сургалтын төлөвлөгөөг нэгжүүдийн хэрэгцээ шаардлага саналыг үндэслэн боловсруулж, албаны даргаар батлуулсан. Сургалтын төлөвлөгөөний дагуу Хувь хүний хөгжил, манлайллын чиглэлээр 4 төслийн 6 сургалт, төрийн болон хувийн байгууллагын 8 сургалт, ТАЗ-өөс зохион байгуулсан 7 сургалт, мэргэшүүлэх чиглэлээр 5 байгууллагаас зохион байгуулсан 13 сургалт, Удирдлагын академийн Төрийн албан хаагчийн 4 багц сургалт гэх мэт нийт 38 төрлийн сургалтад давхардсан тоогоор 256 албан хаагч хамрагдсан. Үүнд:<br>*Танхимаар:*<br>• BGR төслийн 2023.04.13-21-нд зохион байгуулсан сургалтад 6,<br>• Амеп төслийн 2023.05.02-нд зохион байгуулсан сургалтад 2,<br>• CCOP төслийн 2023.09.13-15-нд зохион байгуулсан сургалтад 6,<br>• Япон геологийн албаны 2023.01.17-31-нд зохион байгуулсан сургалтад 1,<br>• Монголын геологийн холбоо 2023.04.23-нд зохион байгуулсан сургалтад 1,<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академи, АЕГазар 2023.05.23, 24-нд зохион байгуулсан сургалтад 1,<br>• ШУТИС, ҮГА, "ГСШТ" ТӨҮГ 2023.05.02-нд зохион байгуулсан сургалтад 2,<br>• АТГазар 2023.09.29-нд зохион байгуулсан сургалтад 1 албан хаагч гэх мэтээр тус тус хамрагдсан.<br>*Цахимаар* ТАЗ-ийн:<br>• 2023.02.02-нд зохион байгуулсан сургалтад 20,<br>• 2023.03.02-нд зохион байгуулсан сургалтад 15,<br>• 2023.04.06-нд зохион байгуулсан сургалтад 12,<br>• 2023.10.19-нд зохион байгуулсан сургалтад 14,<br>• 2023.11.02-нд зохион байгуулсан сургалтад 20,<br>• 2023.11.09-нд зохион байгуулсан сургалтад 21<br>• 2023.11.30-нд зохион байгуулсан сургалтад 11 албан хаагч тус тус хамрагдав.<br>*Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн* | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Ахлах түшмэлийн багц сургалтад 2,<br>-Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2,<br>-Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3,<br>- Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдаж байна. | |
| Зорилт 5.3. Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилго, зорилт 2 Салбарын хууль, эрх зүйн орчны харилцааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх | | | | | | | | |
| 57 | 5.3.1 | Геологи судалгааны чиглэлээрх холбогдох хууль тогтоомжуудын төсөлд санал өгнө. | - | Боловсуулж хүргүүлсэн эсэх:<br>0-хүргүүлээ-гүй;<br>1-хүргүүлсэн | 0 | 1 | - Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮийн сайдын 2022.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан. Уг ажлын хэсэгт ҮГА-ны дарга ажиллаж байна.<br>- Монголын стратиграфийн комиссын ажиллах дүрмийг боловсронгуй болгож Албаны даргын 2023.05.31-ний өдрийн А/11 дугаартай тушаалаар батлуулсан.<br>- Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан ҮГА-ны чиг үүргийн хүрээнд ашиглагдаж буй Хөдөлмөрийн гэрээний загварыг шинэчлэн боловсруулсан.<br>- Ахмад настны тухай хуулийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн Үндэсний геологийн албаны ахмадуудад нийгмийн халамжийн үйлчилгээ, дэмжлэг хөнгөлөлт үзүүлэх зорилго бүхий “Ахмадын сан”-г байгуулж, “Ахмадын сан”-гийн журам “Ахмадын хорооны үйл ажиллагааны” журам батлуулсан.<br>- Ашигт малтмалын тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл, Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний журмын төсөлд санал хүргүүлэв.<br>- 2023.06.06-ны өдрийн А/15 дугаартай тушаалаар албан хаагчдад олгох хоол, унааны нэмэгдэл шинэчлэгдсэн.<br>- Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан, тус журмын 2.2.2.4-р хэсэгт заасны дагуу бүх албан хаагчид хүний нөөцийн мэдээлэл, төлөвлөгөө, тайлан, үнэлгээний хуудаст баяжуулалт хийгдсэн.<br>Албаны даргын 2023.04.12-ны өдрийн А/10 дугаартай тушаалаар ГБТАрхивын даргын АТТ, 2023.07.25-ны өдрийн А/26 дугаартай тушаалаар Улсын төсвийн санхүүжилт, гүйцэтгэл хариуцсан ажилтны АТТ-г батлуулсан. | 100 |
| Зорилт 5.4. Төсөв хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаал. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих | | | | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 58 | 5.4.1 | Батлагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу сар бүр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлийг хүлээн авч санхүүжүүлнэ. | - | Санхүүжүүл-сэн төсвийн хэмжээ /сая.төг/ | 0 |
| 59 | 5.4.2 | Батлагдсан төлөвлөгөөний дагуу аргачлал хяналтын зардлыг зориулалтын дагуу санхүүжүүлнэ. | - | Санхүүжүүл-сэн төсвийн хэмжээ /сая.төг/ | 0 |
| 60 | 5.4.3 | Геологийн судалгааны ажлын төсвийн зарцуулалтыг тайлагнана. | - | Тайлагнасан эсэх: 0-үгүй 1-тийм | 0 |

| | | |
|---|---|---|
| 23,524,8 | Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд зарцуулах төсвийн эрхийг шилжүүлсэнтэй холбогдуулан Геологийн судалгааны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-д нийцүүлэн нийт 11 удаа хянаж нэгтгэн, гүйцэтгэлийн мэдээг, УУХҮЯ болон Үндэсний статистикийн хороонд хүргүүлж ажиллав.<br>Төрийн санд /Геологийн байгууллагын санхүүжилт-100900018019/, /Үндэсний геологийн алба ХОТХяналт-100900018371/, /Үндэсний геологийн алба барьцаа-100900018352/, /10090001853- Үндэсний геологийн алба ТЗ барьцаа/ тоот дансуудаар гүйлгээний эрхийг нээлгэж 45 төслийн гүйцэтгэлийг сар бүр хянаж 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” А/87 тушаалын дагуу 2023 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10 дугаар сарын гүйцэтгэлээр санхүүжилтийн тайланг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав. Тайлант хугацаанд 1-10-р сарын гүйцэтгэлээр 15,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 45 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид олгосон. 2023 оны 12 сард багтаж тайлант хугацааны нийт 22,5 тэрбум төгрөгийн санхүүжилийг олгохоор төлөвлөсөн. | 90 |
| 934,1 | 2023.02.28-ны өдрийн Үндэсний геологийн албаны даргын А/08 дугаар тушаалын дагуу геологи судалгааны ажлын аргачлал хяналтын төлөвлөгөө, төсвийг батлуулан зориулалтын дагуу дараах байдлаар гүйцэтгэл гаргасан. Үүнд:<br>• Зүүн өмнөд Азийн гео-шинжлэх ухааны төрийн байгууллагуудын холбооны 2023 оны гишүүнчлэлийн хураамж-35,2 сая төгрөг,<br>• Монгол Улсын геологийн салбарын улсын зөвлөгөөн зохион байгуулах зардалд 49,3 сая төгрөг,<br>• Хээрийн ажил хүлээн авах зардалд 150,6 сая төгрөг,<br>МСК-ын томилолтын зардалд 56,5 сая төгрөг, нийт 256,5 сая төгрөгийг зарцуулсан. | 90 |
| 1 | Геологийн судалгааны ажилд 2021-2025 оны 81,105.2 сая төгрөг, үүнээс 2023 оны 23,5 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 2023 оны 12 дугаар сарын байдлаар 22,5 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авч, баталгаажуулсан.<br>Геологийн судалгааны төслүүдийн 2024 оны төсөв батлагдсантай холбогдуулан төсвийн хуваарийг гаргаж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Санхүүгийн хэлтэст | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2023/11/29-ний өдөр файлаар болон өдрийн 1/631 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны төслүүдийн 2024 оны төсвийн санал, 2025-2026 онд гүйцэтгэх геологийн судалгааны төслүүдийн төсвийн төсөөллийг боловсруулан 2023/11/29-ний өдрийн 1/632 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| 61 | 5.4.4 | Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлаас санхүүжүүлэх худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-д нийцүүлэн худалдан авалт хийнэ. | - | Худалдан авалт хийсэн эсэх:<br>0-үгүй<br>1-тийм | 0 | 1 | Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлаас худалдан авалт зохион байгуулахаар “Геологийн судалгааны ажлын гүйцэтгэл, тайлан төлөвлөгөөг цахимаар хүлээн авах системийн хөгжүүлэлт” төслийн ажил хийгдэж байна.<br>“Геоэкологийн заавар, зөвлөмж боловсруулах”, “Геофизикийн ажлуудын норм, нормчлол боловсруулах”, “1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар хийгдэх бүх төрлийн сорьцлолтын ажлын зардлын норм, нормчлол боловсруулах” 3 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичиг боловсруулах шатанд байна. | 0 |
| 62 | 5.4.5 | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай бараа, ажил үйлчилгээг худалдан авна. | - | Хуулийн хүрээнд зохион байгуулсан эсэх:<br>1–тийм<br>0–үгүй | 0 | 1 | Үндэсний геологийн алба нь 2023 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын урсгал зардал, улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлэх нийт 2 нэр төрлийн 2,2 тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2023 оны 09 дүгээр сард сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээг байгуулсан. Үүнд: “Геологи хайгуул, судалгааны ажил” зөвлөх үйлчилгээний тендерийн “Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын 5 сувгийн судалгааны ажил”, “Геохимийн 1:200000-ны масштабын судалгааны ажил” 2 багцын хураангуй жагсаалтыг үүсгэсэн. 2023.05.11-ний өдөр урилга нийтэлсэн. 2023.06.12-ны өдөр тендер нээж, үнэлгээ хийгдэж 2023.10.09-нд “Геохими-200” төсөл 1,1 тэрбум төгрөг, 2023.12.01-нд “Геофизик-200” төсөл 2,9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. 2023 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө нь 2,2 тэрбум төгрөг байна.<br>Байгууллагын худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 14 төсөл арга хэмжээнээс<br>- гэрээ байгуулсан -3<br>- шууд худалдан авалтаар 7,<br>- харьцуулалтын аргаар 2,<br>- нээлттэй тендер шалгаруулалтаар-3,<br>- зөвлөх үйлчилгээ, бага үнийн аргаар зохион байгуулах 4 төсөл арга хэмжээ зохион байгуулагдаж байна. Амжилтгүй болсон нэг төсөл байна. Үүнээс:<br>Мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэх тендерийг 2023.03.29-ний өдөр зарлаж, сонгон шалгаруулалт хийж, 2023.05.12-ны өдөр 23/02 тоот гэрээг байгуулсан. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Бичиг хэргийн материал нийлүүлэх тендерийг 2023.03.30, 2023.04.20-ны өдрүүдэд зохион байгуулж амжилтгүй болсон. Барааны хомсдол, үнийн ифляциас шалтгаалан бага үнийн дүн бүхий тендерт аж ахуйн нэгж байгууллагууд оролцохгүй байдал ажиглагдсан.<br>Байгууллагын худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Тээвэр шатахуун, Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс, Багаж, техник, хэрэгсэл, Хөдөлмөр хамгаалал, Урсгал засвар, Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх, Даатгалын үйлчилгээ үзүүлэх зэрэг төсвийн санхүүжилтийн хуваарийн дагуу тухай бүр шууд худалдан авалтаар зохион байгуулсан. Байр ашиглалт-23,1 сая, Урсгал засвар-80,7 сая, Даатгалын үйлчилгээ-6,1 сая төгрөгийг зарцуулсан байна. | |
| 63 | 5.4.6 | Байгууллагын 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг тайлагнана. | - | Тайлагнасан эсэх:<br>1 - тийм<br>0 - үгүй | 0 | 1 | Байгууллагын 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2023.01.05-ны батлуулсан.<br>- tender.gov.mn цахим систем, шилэн данс, байгууллагын сайтад байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангав.<br>Байгууллагаас зарлаж байгаа тендерийн явцын талаар Төсвийн ерөнхийлөн захирагч /Яамны Санхүүгийн хэлтэс/-д 2023.03.27-ны өдөр танилцуулсан. Сангийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай "2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалын дагуу худалдан авах ажиллагааны цахим системд тайланг 2023 оны тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн болно. | 90 |
| 64 | 5.4.7 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалыг үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны дууссан төслүүдийг биет бус хөрөнгөөр бүртгэж авна. | - | Бүртгэсэн төслийн тоо | 0 | 7 | 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Геологи судалгаа хийх гэрээний дагуу тайлангаа хамгаалсан<br>1.Их цог өндөр ХХК-Норивлон-50,<br>2.Алтайн нэгдэл ХХК-Худгийн нуруу-50,<br>3.Дархан мяндгар уул ХХК-Галбын говь-50,<br>4.Эрээн чулуу ХХК-УГЗ-200 нэгтгэл,<br>5.Литолог ХХК-Номгоны нуруу-50,<br>6.Минторес ХХК-Олон гол-50, Магма майнк ХХК-Чулуут хороо-50,<br>7.Гео эрэн ХХК-Шутээн улаан уул-50,<br>8.Эрээнчулуу ХХК-Бүрхтэй уул-50,<br>нийт 9 төслийн тайлан буюу 7,649.3 сая төгрөгийг биет бус хөрөнгөөр бүртгэж авсан. | 100 |
| 5.5 | Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх | | | | | | | |
| 65 | 5.5.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан болон 5 сая төгрөгөөс дээш үнийн | - | Мэдээлэл байршуул-сан сарын тоо | 0 | 12 | Үндэсний геологийн албаны 2023 оны жилийн эцсийн байдлаарх санхүүгийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын санхүүжилт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ, тайлан, аудитлагдсан тайлан, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ. | | | | | аудитын гэрчилгээ, акт, албан шаардлага, бусад мэдээлэл багтаж байна.<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнаж байна. Үүнд:<br>-Төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан,<br>-5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг цаг хугацаанд нь буюу 01-11 дугаар сарын 30-ны байдлаар 326 орлого зарлагын гүйлгээ, тайлан, аудитлагдсан тайлан, аудитын гэрчилгээ, акт, албан шаардлага, бусад мэдээлэлийг олон нийтэд нээлттэй мэдээлсэн байна. /Нийт 74 мэдээ/<br><br>Байгууллагын бүтэц, орон тооны мэдээллийг шилэн дансанд 2023 оны 1 дүгээр сараас сар бүр шинэчлэн оруулж ажиллав.<br>Байгууллагын цахим хуудсанд хагас жилийн байдлаар салбарын үйл ажиллагаатай холбоотой 14 мэдээ, мэдээллийг байршуулсан.<br>Шилэн дансны хуулийн хэрэгжилт 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 90 хувьтай бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад хэрэгжилт 1.6 хувиар, шилэн дансы цахим хуудасанд холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байдал 6.6 хувиар өсч, хугацаа хоцролт 4.5 хувиар, мэдээлэл байршуулаагүй байдал 0.5 хувиар тус тус буурсан байна.<br>Шилэн дансны 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын тайланг гаргаж, хуулийн хугацаанд УУХҮЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газарт хүргүүлсэн.<br>Байгууллагын мэдээлэл, лавлагааны 70181208 дугаарын утсанд ирж буй дуудлагад тогтмол хариу мэдээлэл, лавлагаа өгч, холбогдох ажилтнуудын өрөөний болон гар утас руу дуудлагыг шилжүүлэн, хяналт тавьж ажилласан 70181208, 70181206 утсанд давхардсан тоогоор 2000 гаруй дуудлага ирсэн. | |
| 66 | 5.5.2 | Төсвийн орлого болон зарлагын хэмжээ, хөрөнгө оруулалтыг тооцон, 2023 оны төсвийн тодотгол, 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. | - | Төсвийн төсөөлөл хүргүүлсэн эсэх:<br>0-Үгүй;<br>1-Тийм | 0 | 1 | Үндэсний геологийн албаны 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал, 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөөллийг боловсруулан, 2023.05.03-ны өдрийн 3/233 дугаар албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын программ http://pimis.e-nation.mn/-д оруулсан.<br>ҮГА-ны урсгал төсөв 2020 онд 500 сая төгрөг, 2021 онд 900 сая байсан бол 2023 онд 1,2 тэрбум төгрөгөөр батлагдсан. Мөн тус албаны 2024 оны урсгал төсөв 2 тэрбум төгрөг байхаар батлагдсан нь зөвхөн 2023 онтой харьцуулахад 50 хувиар, 2020 онтой харьцуулахад 150 хувиар нэмэгдсэн үр дүнтэй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын төсөвт 2023 онд нийт 110 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөө ажилласан бөгөөд гүйцэтгэл 176,5 сая төгрөг буюу 66,5%-р орлогын гүйцэтгэл давж биелсэн үр дүнтэй байна. Мөн Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цахимаар олгохтой холбогдуулан УУХҮ-ийн сайдын 2022.04.12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журам” батлагдсан. ҮГА-наас сонгон шалгаруулалаар зарлах талбайн мэдээллийг ялгаж УУХҮЯ-аар дамжуулан АМГТГ-т хүргүүлсэн бөгөөд 2023 оны сонгон шалгаруулалтын орлого нь 40 тэрбум төгрөг болсон нь ҮГА-наас улсын төсөвт төвлөрүүлж байгаа шууд бус орлого болж байна. | |
| 67 | 5.5.3 | Байгууллагын архив байгуулах зураг төслийг боловсруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, хөрөнгө оруулалт шийдүүлэх санал боловсруулж, УУХҮЯ-нд танилцуулна. | - | Танилцуул-сан эсэх 0-Үгүй; 1-Тийм | 0 | 1 | -Архивын баримтын хадгалалт, хамгаалалт,<br>-Аюулгүй байдлыг хангах,<br>-Архивын баримтыг зориулалтын байранд стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлэх зорилгоор Албаны даргын 2023.06.05-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар Албаны архив байгуулах ажлын хэсэг байгуулагдан, зохих журмын дагуу ААН-ийг шалгаруулж, засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу холбогдох стандартын дагуу байгууллагын архив бий болгож ашиглах нөхцөл бүрдсэн. | 50 |
| **Зорилт 5.6. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах, дотоодын хяналтын тогтолцоог сайжруулах, 2021 оны зорилтот түвшин, хүрсэн түвшний зөрүүг бууруулах** | | | | | | | |
| 68 | 5.6.1 | Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнана. | - | Тайлангийн тоо | 0 | 2 | Төсвийн шууд захирагчийн 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2022.12.16-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар хянуулж, батлуулахаар хүргүүлсэн.<br>-Төсвийн шууд захирагчийн 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө 2023.04.16-ны өдөр УУХҮ-ийн сайдаар батлагдсан.<br>-Үндэсний геологийн албаны 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад 2023.06.14-ний өдрийн 1/303 дугаар албан бичгээр, 2023 оны жилийн гүйцэтгэлийн тайлан 2023.12.13-ны өдрийн албан бичгээр УУХҮ-ийн сайдад хүргэгдсэн.<br>-Нийт 71 ажил арга хэмжээ төлөвлөсөн ба, эхний хагас жилд 64 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн тайлагнасан. 7 арга хэмжээг III-IV дүгээр улиралд төлөвлөсний дагуу нийт 71 арга хэмжээний хэрэгжилт тайлагнав.<br>Хүрсэн түвшин: Тогтоосон хугацаанд бүрэн тайлагнав. | 100 |
| 69 | 5.6.2 | Байгууллагын салбарын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Уул | - | Тайлангийн тоо | 0 | 4 | Үндэсний геологийн албаны хэрэгжүүлэн ажиллах хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмуудын хэрэгжилтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023 оны хагас, бүтэн жилийн байдлаар албан бичгээр, цахим хэлбэрээр тус тус хүргэгдсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тайлагнана. | | | | | 2023 онд албанд хийгдсэн үйл ажиллагааны талаарх шалгалтуудыг хяналтад авч, удирдлага зохион байгуулалтаар хангасан:<br>1.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.03.28-ны А/78 дугаар тушаалаар Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 дугаар сарын ХЭГ/595 дугаар бичгээр ирүүлсэн чиглэлийг үндэслэн Үндэсний геологийн албаны Төрийн захиргааны албан хаагчдыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын дагуу албан ёсоор томилогдсон эсэх,<br>- албан хаагч бүрийн 2022, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан, үнэлгээний хуудсууд баталгаажсан эсэх талаарх мэдээллийг хяналт шалгалтын ажлын хэсэгт цаасан хэлбэрээр танилцуулсан.<br>2.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023.05.24-ний өдрийн 06-00-008 дугаар “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийх” ажлын хэсэгт:<br>Геологийн судалгааны төслүүдийн геологийн даалгавар, захиалагчтай байгуулсан 2019-2022 оны гэрээ,<br>2019-2023 оны төсвийн тодотгол,<br>2019-2023 оны гүйцэтгэлийн баримт,<br>2022 онд хамгаалагдах 22 төслийн явц,<br>гэрээ дүгнэсэн акт,<br>хээрийн материал хүлээн авсан акт,<br>нормчлол, санхүүжилт хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт зэрэг бусад шаардлагатай мэдээллийг бэлтгэж өгөх тайлбарууд хийсэн.<br>3.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын үйл ажллагаанд хяналт шалгалт хийх тухай 311 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт:<br>2022-2023 оны Албаны үйл ажиллагааны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, 2020-2024 оны Стратеги төлөвлөгөө, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, албан хаагч бүрийн тайлан, ХШҮ хийгдсэн талаарх тайлан, мэдээллүүд танилцуулсан.<br>Шалгалтаар зөрчил дутагдлын талаар ямар нэг баримт ирээгүй байгаа болно.<br>Нийт хүргүүлсэн тайлан: Албан бичгээр -2, цахим хэлбэрээр -2 удаа. | |
| 70 | 5.6.3 | Шинэ сэргээлтийн бодлого 2022-2025 он /эхний үе шат/,<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга | - | Тайлангийн тоо | 0 | 2 | Үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан дараах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2023.06.14, 12.13-ны өдөр албан бичгээр тус тус хүргүүлсэн. Үүнд:<br>- Шинэ сэргэлтийн бодлого, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ. | | | | | - Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,<br>- Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө. | |
| 71 | 5.6.4 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ. | - | Тайлангийн тоо | 0 | 2 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлтүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж, 2023 оны 12 дугаар сарын 15-нд УУХҮ-ийн сайдад хүргүүлсэн. | 90 |
| **Үнэлгээний дүн** | | | | | | | | **90** |

---o0o---